

**УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ХАНДЛАГА: ОЙЛГОЛТ,  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Ё.Довчин**

Доктор, профессор  
(МУИС, Улс төр судлалын тэнхим)

Соёл бол хүн төрөлхтний туулсан бүхий л үеийн бүтээгдхүүн мөн. Харин түүхийн үүднээс *улстөрийг* нийгмийн хөгжлийн арай хожуу үеийн үзэгдэл гэж болно. Түүхийн өөр өөр цаг үед *соёл, улстөрийн* хоорондын харилцаа янз бүр байжээ. Энэхүү харилцаа зөрчил мөргөлдөөнөөр тодорхойлогдох нь олонтаа байсан хэдий ч соёл хийгээд улстөр нийгмийн амьдрал, үйл ажиллагааг *зохицуулагчын* хувьд харилцан үйлчилсээр ирсэн ажээ. Иймээс өнөөдөр улстөр судлаачид нийгмийн, түүний дотор улстөрийн хүрээний хэвийн оршихуйг соёлын учир холбогдлоор нь судлах учиртайг нэгэнт хүлээн зөвшөөрчээ. Иймд *улстөрийн соёл нийт үндэстний соёлын салшгүй бүрэлдхүүн хэсэг байдаг* гэсэн тулгуур санаа улстөрийн соёлын ойлголт, үзэл баримтлалыг авч үзэх эхлэлийн цэг болж байна. Соёл нийгмийн амьдралын янз бүрийн хүрээний хэм хэмжээ, горим журмыг тодорхойлж “зөвлөж” байдгийн адил улстөрийн соёл улстөрийн хүрээн дэх үйл байдал, тоглоомын дүрмийн хэм хэмжээг мөн тодорхойлж, улстөрийн хүрээг бүхэл, нэгдмэл шинжтэй болгож улстөрийн үйл явцад тодорхой утга агуулга, чиглэл өгч, үйл байдлын хэлбэр, хэв загварыг цаагуур нь тодорхойлж байдаг гэж болох юм. Америкчууд эх орноороо бахархах дуртай, япончууд төрийн албанд хүндэтгэлтэй ханддаг, францчууд тэрс үзэл, тэмцэл эсэргүүцлээс буцдаггүй гэгцгээдэг нь үндэстэн бүрийн соёлын хэм хэмжээ улстөрийн үйл байдлыг хэрхэн өвөрмөц дүр төрхтэй болгодгийн жишээ гэж болно.

Улстөрийн институт, улстөрийн зорилтууд нь ерөнхийдөө ижил төсөөтэй ч тэдгээрийн практик үйл ажиллагааны хэлбэр, улстөрийн үйл явцыг зохион байгуулж буй арга нь улстөрийн систем болгонд ялгаатай байдаг. Энэ нь эдгээрийн цаад талд улстөрийн өөр өөр үнэт зүйлс оршиж, улстөрийн үйл ажиллагааны өөр хэлбэр, механизм ажиллаж байгаагийн гэрч юм. Энэ бүхнийг гол төлөв “улстөрийн соёл” хэмээх ойлголтоор илэрхийлж байдаг.

“Улстөрийн соёл” гэдэг нэр томъёог ХVIII зууны Германы сэтгэгч И. Гердер анх “Хүн төрөлхтний түүхийн гүн ухааны үзэл санаанууд” бүтээлдээ хэрэглэжээ (Гердер, 1977, с.339,368). Харин улстөрийн соёлын цэгцтэй онол номлол бий болсон цаг үе ХХ зууны хоёрдугаар хагастай холбоотой юм. Тухайлбал, Америкийн нэрт улстөр судлаач Габриэл Алмонд 1956 онд “Харьцуулсан улстөрийн системүүд” өгүүлэлдээ улстөрийн соёлын номлолыг томъёолох анхны оролдлого хийжээ. (Almond, 1956) . Г.Алмонд, С.Верба нар 1963 онд хэвлүүлсэн “Иргэний соёл: Таван үндэстний улстөрийн хандлага ба ардчилал” номондоо үндэстэн хоорондын харьцуулсан шинжилгээнд тулгуурлан уг үзэл баримтлалыг баяжуулан хөгжүүлсэн байна (Almond, Verba, 1963, p.14). Мөн 1965 онд гарсан “Улстөрийн соёл, улстөрийн хөгжил” бүтээл улстөрийн шинжлэх ухааны үүднээс улстөрийн соёл хэмээх ойлголтыг судалж боловсруулахад чухал хувь нэмэр оруулжээ.

Улстөрийн соёлын үзэл баримтлал нь өнгөрсөн зууны 30-аад онд нэгэн үе Америкийн Нэгдсэн Улсын улстөрийн шинжлэх ухаанд ноёрхож байсан позитивизм хийгээд сциентизмын эсрэг улстөрийн судалгааны альтернатив онол-арга зүй болж гарч ирсэн гэх үндэстэй. Позитивизмын гол үндэслэлүүдийн нэг нь баримт ба үнэт зүйлсийг зааглах, улстөрийн судалгаанд үнэлэмжийн арга хандлагыг хүлээж авах

боломжгүй тухай постулат байв. Энэ чиглэлийнхэн улстөр судлалыг аливаа үнэт зүйлс, онол, үзэл суртлаас ангид чөлөөтэй байхыг уриалаад үүний оронд байгалийн шинжлэх ухааны судалгааны арга, загваруудаар зэвсэглэж, тухайлбал, математик аргууд, квантификацийг өргөн ашиглах болжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа орчин үеийн улстөрийн шинжлэх ухааны хөгжилд “*бихевиорал хувьсгал*” гэж нэрлэгдсэн үзэгдэл улстөрийн судалгаанд математик арга хэрэглэх, шинэ арга техник нэвтрүүлэх талаар позитивист арга зүйтэй зам нийлж байсан хэдий ч хувь хүн, хэсэг бүлгийн *үйл байдлыг* бүхний түрүүнд судлах зорилго тавьж байсан нь улстөрийн соёлын хандлага үүсэх урьдач нөхцөл болсон гэмээр байдаг. Хэрэв уламжлалт улстөрийн шинжлэх ухаанд институциональ хандлага зонхилж төр-эрх, улстөрийн институцүүдийг хэлбэр-хууль эрхийн талаас шинжилж, нийгмийн улстөрийн зохион байгуулалтын албан ёсны бүтцэд анхаарлаа төвлөрүүлж байсан бол *улстөрийн соёлын хандлага* улстөрийн бодит үйл явцыг, улстөрд оролцогч албан бус субъектүүдийн үйл байдал, тэдгээр институт, бүтцүүдэд хандах хүмүүсийн *чиг баримжааг* судлахад чиглэсэн болно. Уг үзэл баримтлал уламжлалт улстөрийн судалгааны *дескриптив* шинжийг өөрчилж, улстөрийн үйл явцын далд учир шалтгааныг нээн харуулж *тайлбарлахад* чиглэгдсэнээрээ чухал ач холбогдолтой юм. Чухам үүнд улстөрийн соёлын хандлагын шинэлэг тал оршино. Нөгөө талаас улстөрийн соёлын үзэл баримтлал тодорхой нөхцөлд хувь хүний, эсвэл хэсэг бүлгийн улстөрийн үйл байдлыг улстөрийн үзэгдлүүдийн *нийгэм-соёлын* орчинтой холбон үзэхгүйгээр зохих ёсоор тайлбарлах аргагүй гэж үзсэн. Хүний уг чанар соёлтой хүн холбоотой. Хүн *эдийн засгийн, улстөрийн* төдийгүй *нийгэм-соёлын* “амьтан” мөн (Гаджиев, 1997, 512-513 талд үз). Энэ утгаар хүний ухамсарт рациональ бүтцүүд сэтгэл хөдлөл-хүсэл зориг, үндэсний зан чанар, сэтгэл зүй, домог зүйн элементүүдтэй сүлжилдэн оршиж, эдгээр нь улстөрийн үйл явцын чиг хандлага, улстөрийн үйл байдалд ихээхэн нөлөөлж байдаг ажээ. Ийнхүү тооны нарийн хэмжүүрээр хэмжихэд бэрхшээл төвөгтэй хүний оюун санаа, сэтгэл зүй, нийгмийн амьдралын билэг тэмдгийн талыг хөндөж тавьснаараа улстөрийн соёлын номлол позитивист арга зүйгээс ялгардаг гэж болно. Нэг үгээр *улстөрийн соёл бол улстөрийн субъектив тал* юм. Улстөрийн соёл шууд утгаараа улстөрийн институт, аль эсвэл улстөрийн үйл явц биш, харин улстөрийн ертөнцийн тухай, түүний оршихуйн зүй тогтол, хууль дүрмийн тухай хүмүүсийн аливаа нийтлэгийн *төсөөллийн* цогц байдаг.

Сүүлийн жилүүдэд улстөр судлаачид улстөрийн аливаа үзэгдэл, улстөрийн дэглэмийн мөн чанар, онцлогыг соёлын хандлагаар тайлбарлах болжээ. Энд жишээ болгож Р.Инглехарт (1990), Путнам (1993) нарын үзэл санаа, шинжилгээ судалгааг дурдаж болно.

Түүнчлэн ардчиллын гуравдахь давалгааны судлаачид дэлхийн улс орнууд, бүс нутгийн заримд нь ардчилал тогтвортой хөгжиж байхад нөгөө хэсэг нь авторитар улстөрийн системтэй байдгийн учир холбогдлыг гол төлөв тэдгээр улс үндэстний уугуул соёлын үнэт зүйлстэй холбон үзсэн байдаг (Huntington, 1996, p.218-219) Тэдний үздэгээр соёл ардчилсан хөгжлийг дэмжиж тэтгэх, эсвэл хорьж хязгаарлах чадамжтай байдаг ба энэ нь тухайн соёлд ардчилалтай нийцэж тохирох хэм хэмжээ, үнэт зүйлс биеллээ олсон эсэхээс хамаардаг байна. Ардчилал бол христосын шашин (ялангуяа протестантизм), хувь шинжийн үзэл, төр сүм хийдийг тусгаарлах номлол, үндэсний төр улсын төлөвшил, аж үйлдвэржүүлэлт, капитализмын хөгжил зэргээр мөн чанар нь тодорхойлогддог Европын түүхэн туршлагын өвөрмөц онцлог бүтээгдхүүн. Эдгээр хүчин зүйлс нь эрх чөлөөг эрхэмлэдэг либерал үнэт зүйлст тулгуурласан ардчилсан системийг бий болгодог бөгөөд ийм нийгмийг “*Өрнөдийн*” хэмээн нэрлэж заншжээ. Зарим эрдэмтдийн бодлоор либерал үнэт зүйлс түгээмэл

шинжтэй биш. Иймээс өөр бусад нийгэм өрнөдийн ардчилсан практиктэй үл тохирох хэм хэмжээ, институтүүдээс бүрэлддэг байна. Сүүлийн хэдэн арван жилд бэл бэнчин нь огцом өсч буй Ойрхи дорнодын газрын тосны арвин баялаг нөөцтэй орнууд үүний жишээ болдог ажээ. Мөн исламын соёлтой улсуудад шашин, үндэстэн, төрийн хоорондын харилцаа нь авторитар систем ба соёлын шүтэлцээг харуулдаг гэж үзэх нь ч бий. Үүгээр ч зогсохгүй бас “Азийн үнэт зүйлс” (Pye,1995) нь хувь үзэл, ардчилал, эрх чөлөө гэсэн өрнөдийн ойлголтуудтай зөрчилддөг талаар мэтгэлцдэг. Азийн соёл, шашны уламжлал номхон хүлцэнгүй төлөв, ихэс дээдэс, ах захын ёс, дуулгавартай зан чанарыг чухалчилдаг нь нийгмийн зохицол, зөвшлийн эрх ашгийн үүднээс эрх чөлөөг хязгаарладаг улстөрийн системд илүү зохимжтой ажээ. Үүнийгээ нотлохын тулд гол төлөв Күнзийн сургаалаас иш татдаг. Гэвч тус бүс нутагт авторитар дарангуйлал жам ёсны гэсэн санааг цаагуураа баталж байгаа энэ “Азийн үнэт зүйлс” гэгчийг олон судлаачид няцаадаг. Тэд Азийн соёлын олон хэмжүүрт нарийн нийлмэл шинжийг дутуу үнэлсэн, улмаар авторитар дэглэмийг зөвтгөх гэсэн оролдлого хэмээн шүүмжилж буй. Хэрэв уг сэдвээр маргаан цааш үргэлжилбэл католик шашинтай орнууд, бүс нутагт авторитар дэглэм удаан хугацаагаар ноёрхож байсныг бас сануулах хэрэгтэй болно. Гэхдээ энэхүү мэтгэлцээн нь үндэстэн бүрийн соёл, түүний дотор улстөрийн соёл өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдгийг үгүйсгэсэн хэрэг огт биш нь ойлгомжтой.

Ийнхүү улстөрийн соёл хэмээх ухагдхуун дор чухам юуг ойлгох вэ? Улстөрийн соёлын тодорхойлолт янз бүр байдаг нь асуудлын нарийн төвөгтэй, олон хувилбарт шинжийг заахын хамт улстөрийн шинжлэх ухааны өргөн хүрээтэй, гүнзгий утга агуулгатай ойлголт гэдгийг давхар илтгэж буй хэрэг.

Саяхан болтол түүхчид, антропологичид, сэтгэл судлаачид *үндэсний зан чанар, уламжлал* улстөрийн үйл явдлыг тодорхойлдог хүчин зүйлс болох тухай өргөн ярьж бичиж байв. Иймээс “улстөрийн соёл” гэдэг нэр томъёо чухамдаа “үндэсний зан чанар”-ыг шууд залгамжилсан гэхэд болно. Үндэсний зан чанарын онцлогийг олж илрүүлэх гол зорилт нь ямагт өөр өөр ард түмний төлөөлөгчдийн үйл байдал, уламжлал, соёлын хатуу хэвүүдийн ялгааг эрж хайхад оршиж байв. ХХ зууны 40-50-иад оны үеийн үндэсний зан чанарын судалгаа янз бүрийн үндэстнүүдийн үнэт зүйлсийн чиг баримжаа, суурь ухамсарт чиглэж, тэгснээрээ уул үндэстний сэтгэл зүйн хөргийг бүтээх зорилготой байжээ. “Үндэсний зан чанар”-ын үзэл санааны дор тодорхой үндэстэнд байдаг, түүний уламжлалд бэхжиж үлдсэн ёс суртхуун, соёл, улстөрийн болон бусад төсөөллүүдийн нийлбэр цогцыг ойлгож байв.

Үндэсний зан чанарын анхны эмпирик судалгааг дэлхийн хоёрдугаар дайны дараа америкчууд хийсэн бөгөөд судалгааны объектоор тухайн үеийн өөрсдийн “дайсан” - германчууд, япончуудыг сонгож авсан байна. Судлаачдын зорилт нэг талаас үндэсний сэтгэл зүйн онцлог, нөгөө талаас авторитаризм, фашизмын тархалтын хоорондын харилцан шүтэлцээг олж илрүүлэхэд байжээ. Түүнчлэн хүйтэн дайны үед орос зан чанарыг судалсан гаднын эрдэмтэд уг үзэгдлийн онцлог болох хүлцэнгүй, идэвхгүй, дээдэстээ үг дуугүй захирагддаг чанарыг оросуудын хүүхдээ чанга өлгийддөг уламжлалтай холбож тайлбарласан байдаг ажээ.

Гэвч судлаачдын дараачын үеийнхэн энэ мэтийн хэт болхи гэмээр арга зүйгээс татгалзаж, энэ нь судлаачдын ёс зүйгээс төдийгүй тэд үндэсний зан чанарыг оновчтой “хэмжиж” чадаагүй, улстөрийн мэдлэг дутмаг, асуудалд бодитой хандаагүй зэргээс болсон гэж шүүмжлэх болжээ. Үүнээс улбаалан 50-иад оны сүүлчээс дээр дурдсанчлан аж үйлдвэржсэн барууны хөгжингүй орнуудад хэрэгжүүлсэн улстөрийн шинэтгэл, модернизацийн загваруудыг Ази, Африк, Латин Америкийн шинэ тутам тусгаар тогтносон улсуудад нэгэн адил үр дүнтэй хэрэглэж болохгүй байгаа, улс орнуудад олон түмний улстөрийн оролцоо эрчтэй өрнөсөн, авторитар, тоталитар

дэглэмийн мөн чанарыг ул суурьтай шинжлэх шаардлага тулгарсан зэрэгт хариулт болгож улстөрийг судлах шинэ арга хэрэгслийг эрэлхийлэх хэрэгцээ гарч иржээ. Энэ нь улстөрийн өөрчлөлтүүдийн *соёлын учир холбогдлыг* улстөр судлаачдын анхаарлын төвд тавьсан байна.

Орчин үед улстөрийн ном зохиолоос улстөрийн соёлын хэдэн арван тодорхойлолтыг олж үзэж болох бөгөөд тэдгээрийг тоймлон авч наад зах нь гурван чиглэлд хамаатуулан ялгаж болох юм. Үүнд:

1. Улстөрийн соёлыг чиг баримжаануудын цогц хэмээн цэвэр субьектив талаас авч үзсэн сэтгэл зүйн тодорхойлолт (Г.Алмонд, Л.Пай, П.Шаран, М.Доган, Д.Пеласси г.м)
2. Үнэлэмж, төсөөлөл, итгэл үнэмшилээс гадна үйл байдлын загваруудыг багтаан үздэг улстөрийн соёлыг өргөн утгаар авч үзсэн тодорхойлолт (Р.Такер, У.Розенбаум, Е.Вятр г.м.)
3. Улстөрийн соёлд улстөрийн туршлага, бие хүний мэдлэг, хүмүүжлийн хүрэх тодорхой төвшин, арга хэрэгсэл талаас хандсан үнэлгээний шинжтэй тодорхойлолт (Муругова В., Шапко В., Бабосов Е. г.м.)

Улстөрийн соёлд өгсөн эл тодорхойлолтууд судалгааны зорилго, чиглэл, судлаачын байр сууринаас хамаарч уг үзэгдлийг өөр өөр өнцгөөс харж тайлбарласныг харуулдаг. Гэхдээ тодорхойлолтуудад улстөрийн соёлын мөн чанар нь улстөрийн тухай иргэдийн субьектив төсөөлөлд оршино гэсэн санаа нэвт шингэсэн байгааг цохон тэмдэглэж болно. Улстөрийн соёлын үзэл баримтлалыг эхлэн боловсруулагчид бол үндсэндээ *сэтгэл зүйн* чиглэлийнхэн байв.

Улстөрийн соёлын үндсэн ойлголт, баримтлалуудыг америкийн эрдэмтэн С.Верба, Л.Пай, Г.Алмонд, С.Липсет, Р.Такер болон бусад онолчид боловсруулсан юм. Эдгээр улстөр судлаачид улстөрийн соёлыг тодорхой үнэт зүйлсийн цогц, түүний дотор нь улстөрийн систем оршин байдаг гэж төсөөлж байв. Г. Алмонд (1956) эхэн үеийн судалгаандаа улстөрийн соёлыг *улстөрийн системийг өөртөө багтаасан улстөрийн объектуудад хандах чиг баримжааны онцгой хэв маяг* хэмээн тодорхойлжээ. Хувь хүмүүсийн *улстөрийн чиг баримжаа* гурван элементээс бүрдэг байна. Үүнд:

- Танин мэдэхүйн чиг баоимжаа буюу улстөрийн объектууд, үзэл санааны тухай үнэн зөв эсвэл буруу мэдлэг;
- Мэдрэмжийн чиг баримжаа буюу улстөрийн объектуудын хувьд өөрийн холбоо харилцаа, оролцоо, эсэргүүцэл зэргийн мэдрэмж;
- Үнэлгээний чиг баримжаа буюу улстөрийн объектууд, үйл явдлын талаар үнэлгээ, бодомж, санал бодол.

Эдгээр чиг баримжаа бие хүний хувьд ч нийгмийн төвшинд ч харилцан адилгүй хувь хэмжээтэй оршиж болно. Тодорхой шатанд чиг баримжаанууд нийлж хослол болдог нь улстөрийн соёлын шинэ хэв маяг үүсэх урьдач нөхцлийг бүрдүүлдэг байна.

Улстөрийн соёлын ухагдхууныг гүнзгийрүүлж Л.Пай, Е.Верба нар *"улстөрийн шийдвэрүүдийг ач холбогдолтой болгож, институтүүдийг цэгцэлж, хувь хүмүүсийн үйл хөдлөлд нийгмийн утга санааг шингээн өгч байдаг улстөрийн субьектив урсгал"* гэж тодорхойлсон байна. Эндээс үзэхэд улстөрийн соёлын баримтлал улстөрийн салбар нь дан ганц *институтжсэн хэлбэрүүдтэй* байх учиргүй гэсэн шинэ санааг дэвшүүлсэн нь илт байна. Улстөрийн соёлыг судлах нь юуны өмнө улстөрийн үзэгдлийн сэтгэл зүйн бүрэлдүүлбэрийг нээж гаргахад чиглэгдэх ёстой байв. Л.Пай улстөрийн соёл бол улстөр хэмээх үзэгдлийн *сэтгэл зүйн хэмжээс* болдог гэжээ.

Дурдсан эрдэмтдийн улстөрийн соёлын тухай сонгодог тодорхойлолт нь улстөрийн соёлыг *чиг баримжаануудын тодорхой загвар, үнэт зүйлс, билэг тэмдэг, итгэл үнэмшил, улстөрийн үйлдлийн үнэлэмжийн систем гэсэн* ойлголтод хүргэж байна. Тухайлбал, “Нийгмийн улстөрийн соёлын тухай ярихдаа бид гишүүдийнхээ *мэдлэг, мэдрэмж, үнэлэлтэд* уусаж орсон улстөрийн системийг хэлж байгаа юм” гэж бичсэн нь үүнтэй утга дүйцэж байна (Pye, Verba, 1965, p.7). Эндээс үзэхэд *улстөрийн систем ба улстөрийн соёл* нь бие даасан дэд системүүд боловч тэдгээрийг зааглах хатуу шугам татах нь тун ярвигтайг харуулж, улстөрийн систем, улстөрийн соёл нь харилцан нөлөөлж, сүлжилдэж нэг нь нөгөөгүйгээр оршин тогтнох аргагүй гэдгийг баталж байна.

Улстөрийн соёлыг *илүү өргөн утгаар авч үздэг чиглэлийн* төлөөлөгчид улстөрийн системийн тухай төсөөллийн үр дүнд хүмүүс бас улстөрийн үйл байдлын тодорхой загваруудыг мэдэж авч эзэмшиж байдаг гэж үздэг. *Улстөрийн үйл байдал* гэдэг нь хүн улстөрийн орчинтой практик дээр харилцан үйлчилж тэр нь улстөрийн оролцооны ямар нэг хэлбэрээр дамжин илэрч байгааг хэлж болох юм. Нэг үгээр улстөрийн үйл байдал улстөрийн соёлын төвлөрсөн илэрхийлэл болдог. Улстөрийн үйл байдал улстөрийн үйл ажиллагаанд тусгалаа олж байдаг гэж үзвэл *улстөрийн соёл* нь улстөрийн мэдлэг, итгэл үнэмшил, мэдрэмж, үнэлэмж, чиг баримжаа зэргээр тодорхойлогдож байдаг улстөрийн үйл ажиллагааны хэлбэрүүдийн тогтвортой шинж бүхий нийлбэр цогц гэж болох бөгөөд нэг үгээр *мэдлэг, итгэл үнэмшил, үйл байдлын загваруудын нэгдэл* гэж ойлгож болно. Ийнхүү улстөрийн хийсвэр төсөөллийг бодит амьдрал дээр буулгаж улстөрийн үйл ажиллагаа, үйл байдалтай холбож өгснөөрөө тус чиглэлийнхний баримтлал давуутай гэж болох юм.

Улстөрийн соёлын олон талт чанар үүгээр шавхагдахгүй нь ойлгомжтой. Эрдэмтэд улстөрийн соёлыг нэг талаас хүний хувийн туршлагын үр дүн, нөгөө талаас улстөрийн системийн түүхийн тусгал болж байдаг гэж үзэх нь бий. Мөн үндэстэн, анги, бүлгийн улстөрийн хамтын туршлагын синтез гэдэг. Америкийн Клемсоны их сургуулийн профессор М.Сланн “аливаа үндэстний туулж өнгөрүүлсэн түүхэнд тохиолдсон томоохон үйл явдлууд тухайн үндэстний улстөрийн соёлд гүнзгий ул мөр, “шарх сорви” үлдээдэг” гэж тэмдэглэжээ (Slann, 1998, p.62-63). Иймээс *улстөрийн соёлыг уламжлал, ёс заншил, хэм хэмжээ, үйл байдлын загваруудын хэлбэрээр нэг үеэс нөгөөд дамжин өвлөгддөг улстөрийн практикын бэхжиж тогтсон туршлага* гэж үздэг байна. Жишээ нь, Оросын эрдэмтэн Ф.М. Бурлацкий улстөрийн соёл нь нийгмийн туулж өнгөрүүлснийг “хальсандаа” буулгасан “ой ухаан”, тэр нь хууль эрх, ёс заншил, улстөрийн ухамсарт шингэж үлдсэн байдаг гэсэн үзэл санааг үндэслэн тодорхойлолт өгсөн байдаг (Бурлацкий 1974,с.113).

Түүнчлэн сүүлийн жилүүдэд тухайлбал, ардчилсан шилжилтийг хэрэгжүүлж буй улстөрийн системүүдэд улстөрийн соёлыг *үнэлэлт* маягаар төсөөлж, түүнийг гол төлөв эерэг утгаар ойлгож авч үзэх нь нэлээд дэлгэрсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засаг-улстөрийн шинэтгэлийн алдаа доголдлыг, ардчиллах үйл явцын удаашралыг улстөрийн соёлын төвшин доогуур байгаатай холбон тайлбарлаж байна. Энэ нь иргэд улстөрийн үйл байдлын идеал загваруудыг хэрхэн өөрийн болгож байгаатай уялдуулж улстөрийн соёлын төвшин өндөр байх ёстой гэсэн санаа юм. Хэдийгээр тоон үзүүлэлт талаас ийм хандлагыг үгүйсгэхгүй ч улстөрийн шинжлэх ухаанд улстөрийн соёлын агуулгыг ямар нэг байдлаар сурталжуулах явдал байж болохгүй нь мэдээж. Хэн нэгэнд таатай, таагүй эсэхээс үл шалтгаалан үндэсний улстөрийн соёл объектив үнэт зүйлсийн системд суурилах бөгөөд түүнийг улстөр судлаач олж тогтоож судлах үүрэгтэй. Иймд аливаа нэг улстөрийн соёлыг бусдаас цойлон шалгарсан, төгс боловсронгуйн зиндаанд өргөмжлөх нь үргэлж хурц шүүмжлэлтэй тулгарч байдгийг харгалзан үзвэл зохино. Хэрэв өөрийн үндэсний улстөрийн соёлын

онцлогыг үл ойшоох нь дэлхийн хамгийн шилдэг гэгдэх загваруудыг зээлдэн авсан тохиолдолд ч тэр болгон үр дүнтэй байдаггүйг улс орнуудын туршлага харуулсан байна. Учир иймээс аливаа үндэсний хийгээд хувь хүмүүсийн улстөрийн соёлыг боловсорсон, боловсроогүйд үнэлэлт дүгнэлт өгөх нь ихээхэн судалгаатай, анхаарал болгоомжтой хандахыг зүй ёсоор шаарддаг ажээ.

Ийнхүү улстөрийн соёлын талаар өөр өөр хандлагууд байгаа нь тухайн үзэгдлийн нарийн нийлмэлийг гэрчилж байгаа хэрэг. Гэхдээ үзэл бодлын ялгаа нь улстөрийн соёлыг улстөрийн системийн субъектив тал, улстөрийн нийгэм-соёлын хэмжээс хэмээн ойлгохыг хүлээн зөвшөөрдөггүйд биш, харин судалгааны арга тактик талд илүүтэй оршиж байгааг тэмдэглэж болно. Энэ утгаар улстөрийн соёл улстөрийн үйл явцын цор ганц *детерминант* биш юм. Гэвч улстөрийн соёл улстөрийн үйл явдлуудын явцад бодитой нөлөөлж, үйл явцыг хурдасгагчын эсвэл удаашруулагчын үүргийг гүйцэтгэдэг гэдэг нь тодорхой байна.

Улстөрийн соёлыг улстөр-сэтгэл зүйн бусад үзэгдлүүдээс ялгахад туйлын төвөгтэй байдаг нь түүний илрэлийн дийлэнхи нь оюун санаа, ухамсартай холбоотой, материаллаг бус шинжтэй байдагт оршдог. Гэхдээ улстөрийн соёлын үнэт зүйлс оршин буйг институцийн хэлбэр, хууль цааз, төрийн сүлд, далбаа, орд харш, төрийн байгууламжын хэв маяг гэрчилдэгийг үгүйсгэхгүй. Жишээ нь, Их Британи албатын соёлын сонгодог жишээ гэж тооцогддог бөгөөд уул соёлын цөм нь хаант ёсыг эрхэмлэн дээдлэхэд оршдог. Хатан хаан иргэдийн улстөрийн үзэл бодлоос үл хамааран, хүн амын олонхийн хайр хүндэтгэлийг хүлээж байдаг байна. Английн нэг адил сүүлийн 150 гаруй жилийн францын уламжлал төрийн засаглалын бүгд найрамдах хэлбэрт үнэнчээ илтгэсээр иржээ. Олон судлаачид улстөрийн соёлыг улстөрийн тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл гэж үзэхийн хамт улстөрийн соёлын бүтцэд зөрчил шийдвэрлэх аргыг багтааж үздэг нь анхаарал татдаг. Зарим улс гүрэн олон улсын хийгээд дотоодын зөрчил мөргөлдөөнийг хүч хэрэглэж шийдвэрлэхийг урьдал болгох нь байдаг. Эсвэл улстөрчид өөр хоорондоо тэрсэлдэж, улстөрийн үзэл бодлоороо ойролцоодуу ч эвсэл холбоонд нэгдэж чадахгүй, хэл амаа ололцохгүй байх нь цөөнгүй. Тэд юуны өмнө өрсөлдөгчөө тэмцлийн талбараас яаж ийгээд бушуухан “арчихыг” яарна. Энэ нь хүлцэл тэвчил, зөвшилцөл, олон ургальч үзэл улстөрийн соёлын бүтцэд нь сайн “сууж” өгөөгүйн гэрч юм. Улстөрийн соёлын бүтцэд улстөрийн мэдлэг - онол, үзэл баримтлал, үзэл санаа, зарчмууд; улстөрийн мэдрэмж, үнэлэмж, сэтгэл зүйн байдал; норматив элементүүд - ёс заншил, уламжлал, хатуу хэв; улстөрийн үйл байдлын загварууд- идэвхтэй, идэвхгүй, хувь хүний, хамт олны гэх мэт хэд хэдэн бүлэг элементүүд багтдаг. Эдгээр нь бүхэлдээ улстөрийн соёлын агуулгыг дүүргэж, улстөрийн харилцааны ямарваа системд хүн хэрхэн үйлдэл хийдэг, тэрбээр улстөрийн аливаа үнэт зүйлсэд яаж ханддаг, улстөрийн өөрчлөлтөд хэрхэн хариулж байгаа зэрэгт хариу өгөх үндэс болно. Улстөрийн соёлыг бүрдүүлэгч элементүүд нийт үндэстний соёл, нийгэм, түүх, үндэс угсаа, шашны уламжлал, ёс заншил, хатуу хэв загвар, домог, билэгдэлтэй салшгүй холбоотой байдаг. Иймд үндэстний соёлын суурь бүрэлдүүлбэрүүд нь улстөрийн итгэл үнэмшлийн систем, улстөрийн соёл бүхэлдээ бүрэлдэн төлөвшихөд ихээхэн нөлөө үзүүлдэг байна. Ийнхүү улстөрийн соёл олон арван жил, олон үеийн туршид бүрэлдэж бий болсон *улстөрийн уламжлал, улстөрийн практикын хэм хэмжээ, нийгэм-улстөрийн янз бүрийн институтын хоорондын харилцааны тухай үзэл санаа, үзэл баримтлал, итгэл үнэмшлийг агуулж байдаг* нь илэрхий байна. Эдгээр бүрэлдүүлбэрүүдийг нийгэм-эдийн засаг, түүх-соёлын урт хугацааны хүчин зүйлс нөхцөлдүүлдэг учраас тэдгээр нь харьцангуй тогтвортой, “амьдрах чадвартай”, нийгмийн ахуйн хувьсал хувирлын явцад өөрчлөлтөд өртөхдөө алгуур удаан байдаг онцлогтой. Улстөрийн соёлын элементүүдийг нарийвчлан задлан ялгаж үзэх нь

түүний янзбүрийн загваруудын эмпирик судалгаанд ач холбогдолтой. Үндсэндээ улстөрийн соёлын элементүүд нэг хэсэг нь *улстөрийн ухамсрын*, нөгөө нь *улстөрийн үйл байдлын* хүрээнд багтдаг талаар дээр цухас дурдсан. Улстөрийн соёлын тодорхойлолт ч ийм санааг илэрхийлж буй. Улстөрийн ухамсрын бүтцэд ордог элементүүдээс хамгийн чухал нь тухайн улстөрийн системийн талаар тогтвортой чиг баримжаануудын цогц байдаг. Тухайлбал, иргэд нь өөрийн улстөрийн системдээ байнга ээвэргүү ханддаг улстөрийн соёл байдаг. Энэ нь үндэсний бахархал, эх оронч үзлээр дамжин илэрч болно. Энд харьцангуй тогтвортой чиг баримжааны тухай ярьж байгаа хэрэг. Гэхдээ бас улстөрийн өдөр тутмын практикт хувьсаж өрчлөгдөж байдаг засгийн газар, парламент, ерөнхийлөгч, улстөрийн лидерүүд, намын рейтинг, улстөрийн чухал шийдвэр, улстөрийн онцлог үйл явдлын талаар хүмүүсийн үнэлэмжийг мэдэж байх нь улстөрийн соёлын илүү тогтвортой параметруудийг олж ажиглахад хэрэгтэй байдаг байна.

Ер нь үндэстний улстөрийн соёлд *иргэдийн чиг баримжаа гурван объектод ханддаг* гэж болох юм. Нэгдэх нь дурдсан *улстөрийн системд* хандсан чиг баримжаа. Хоёрдахь нь *улстөрийн үйл явц* ба бодлого боловсруулах явцад хандах чиг баримжаа байна. Энэ нь улстөр хэрхэн “ажиллаж” “амьдрах” тухай ойлголт, улстөрийн үйл явцад хандах хувь хүмүүсийн харилцаа, нэг үгээр иргэдийн улстөрийн үйл явц дахь үүрэг ролийг илтгэдэг байна. Үүрэг роль талаас иргэд гурван янз байж болно: Улстөрд бодитой оролцдог, эсвэл оролцоход бэлэн байдаг –*оролцогчид*; *албатууд*- тэд төрийн албан тушаалтнууд, мөн хуулийг сонсож идэвхгүй дагаж мөрддөг, саналаа өгөхгүй, эсвэл улстөрд идэвхтэй оролцохгүй байх; *өвгийнхөн*- улстөр, засгийн газрын талаар мэдээлэл байхгүй, бичиг үсэггүй, алс бөглүү хязгаар нутгийнхан, эсвэл улстөрийг огт хайхарч үздэггүй хүмүүс. Гуравдахь нь төрийн бодлогын эцсийн үр дүнд хандах чиг баримжаа юм. Төрийн бодлогын зорилго ямар байх ёстой, түүнд хэрхэн хүрэх талаар иргэдийн хүсэн хүлээлт гол үзүүлэлт болдог. Тухайлбал, иргэдийн амьжиргааг сайжруулах, нийгмийн хамгааллыг анхаарах, нэг үгээр нийгэм, эдийн засгийг удирдахад төрийн үүрэг роль ямар байх талаар хүмүүсийн төсөөлөл, хандлагаар уул чиг баримжаа илэрч байна гэсэн үг.

Улстөрийн ухамсрын элемент - чиг баримжаа, үнэлэмж, төсөөлөлөөс гадна улстөрийн соёл бол улстөрийн үйл байдлын зохих загваруудыг агуулж байдгийг дурдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл улстөрийн ухамсрын элементүүдийг задалж ялгаж авч үзэхийн зэрэгцээ тэдгээр нь тодорхой улстөрийн үйл явцад, нийгмийн янз бүийн бүлэг, давхаргын үйл байдалд хэрхэн яаж бууж хэрэгжиж байгаа нь анхаарал татдаг. Учир нь өөр өөр хүмүүс хэсэг бүлгүүдийн адил төсөөтэй улстөрийн үнэлэмж, үнэт зүйлс-хэм хэмжээний чиг баримжаа, үзэл санаа-улстөрийн зарчмууд улстөрийн тодорхой үйл байдалд янз бүрээр илэрч гардаг оршино. Бид дээр улстөрийн зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх үндэстний уламжлал харилцан адилгүй байдгийг хөндсөн. Мөн энэ тухайд үндэстний улстөрийн соёлын бас нэг онцлог нь хямралын нөхцөлд хүн ам, түүнчлэн улстөрийн хүчнүүдийн өгөх хариулт, үйл байдал байдаг байна.

Нэгдмэл улстөрийн соёлын хүрээнд дэд соёлууд байж болох бөгөөд тэдгээрт шашин, үндэс угсаа, бүс нутгийн шинжүүд ямар нэг хэмжээгээр зонхилж байдаг. Мөн нийгмийн гишүүдийн онцлог үзэл бодол, үнэлэмж, төр засаг, лидерүүдэд хандах харьцаа, улстөрд оролцох байдал ч дэд соёлыг үүсгэж болно. Энэ бүхнийг янз бүрийн улс орнууд, ард түмнүүдийн улстөрийн соёлыг судлахад харгалзах хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл улстөрийн соёлын үндэстэн ястнуудын, нутаг дэвсгэрийн олон хувилбарууд байдгийг иш үндэс болгоно гэсэн үг. Жишээ нь, Европ, Ойрхи дорнодын хувьд ч юм уу, эсвэл өрнө, дорнын хувьд ч юм уу улстөрийн соёлын нэг загвар байж болохгүй нь ойлгомжтой. Улстөрийн дэд соёл гэдэгт нийгмийн бусад

бүлгүүд, түүгээр ч барахгүй нийт үндэстний улстөрийн чиг баримжаа, үйл байдлын загвараас зарим талаараа өвөрмөц ялгардаг тодорхой бүлгийн улстөрийн чиг баримжаа, улстөрийн үйл байдлын загваруудын нийлбэр цогцыг ойлгож болох юм. Улстөрийн соёлыг хүн амын олонхи хуваалцдаг *үнэт зүйлс-хэм хэмжээний систем* гэж үзэж болно. Үүний хамт улстөрийн соёлыг зөвхөн нийгэм бүхэлдээ дэмждэг үнэт зүйлс, итгэл үнэмшил, билэг тэмдгийн систем, басхүү ердөө л улстөрийн системд хандах эерэг үнэлэмжээр хязгаарлах нь буруу. Иймээс тухайн нөхцөл байдлыг өөрчлөхийн төлөө тэмцдэг социаль бүлгүүдийн улстөрийн итгэл үнэмшил, үнэт зүйлс, үнэлэмжийг харгалзан үзэх хэрэгтэй болдог. Энэ нь ноёрхогч улстөрийн соёл, дэд соёлууд нэгэн зэрэг зэрэгцэн оршиж болохыг зааж байна. Нийтийн улстөрийн соёлын сегментүүдийн уг соёлоос ялгарах ялгаа нь зарчмын бус шинжтэй байж болно. Харин улстөрийн дэд соёл илүү бие даасан шинжтэй байдаг учраас нийтийн улстөрийн соёлоос заримдаа онцгой тод ялгарах нь элбэг байна.

*Хэл –үндэс угсааны* дэд соёл социаль бүлгүүдийн хэл, угсаа гарвалын онцлогтой холбоотой бөгөөд ялангуяа олон бүрэлдхүүнт нийгэмд ийм дэд соёл тод томруун илрэх нь бий. Эдгээр бүлгийн улстөрийн соёлд үндэстний зан чанар, үндэстний ухамсар шийдвэрлэх нөлөө үзүүлдэг. Умард Ирланд, Иран улсуудад *шашны дэд соёл* эдгээр орнуудын улстөрийн амьдралд бүхэлд нь асар их нөлөөлсөн байдаг. Судлаачдын анхаарлаа хандуулдаг нэг дэд соёл бол *эсэргүүцлийн* буюу “дайсагнасан дэд соёлууд” юм. 80-аад онд үүссэн эсэргүүцлийн хөдөлгөөнүүд өөртөө албан ёсны үзэл суртлаас зөрүүтэй улстөрийн үнэт зүйлсийг агуулж байснаар анхаарал татсан байна. Үүний жишээ нь хүрээлэн буй орчноо цэвэр ариун байлгахын төлөө хөдөлгөөн байв. Зөвхөн Гринпис байгууллагын талынхан гэхэд өөрийн улстөрийн тэмцэлд сая сая хүмүүсийг татан оролцуулсан байна. Францын цөмийн туршилтын эсрэг өрнөсөн эсэргүүцэл хэрэг дээрээ дэлхий дахинд олон нийтийн идэвхийн урьд байгаагүй “тэсрэлт”-ийг өдөөсөн ажээ. АНУ-д 1995 онд болсон “сая хар эрчүүдийн марш” олон хүний хувьд гэнэтийн үзэгдэл байлаа. Эсэргүүцэл цаагуураа нөхцөл байдлаас үүссэн хүчин зүйлсэд захирагддаг төдийгүй улстөрийн шинэ дэд соёлууд бий болдог нэлээд тогтвортой орчинд боловсордогыг улстөр судлаачид ажиглаж судалсан байна.

Дэлхийн үндэстэн бүр өөрийн улстөрийн соёлтой гэж үзвэл улстөрийн соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Шинжлэх ухааны зорилго энэхүү олон янз байдал дундаас адил төсөөтэй зохих соёлын бүлгүүдийг ялгах ямар нэг үндэслэлүүдийг эрж хайхад оршино. 1960-аад онд америкийн эрдэмтэн Алмонд, Верба нарын санал болгосон улстөрийн соёлын гурван үндсэн, хэд хэдэн холимог хэв маягийг сонгодог ангилалд тооцдог. Энэхүү хэв маягчлалыг Америкийн Нэгдсэн Улс, Англи, Герман, Итали, Мексик гэсэн таван орны улстөрийн амьдралыг судалсны үндсэн дээр боловсруулсан юм. Тэдний дэвшүүлсэн гурван үндсэн улстөрийн соёлын загварыг *өвгийн* буюу уламжлалт, *албатын*, *оролцооны* хэмээн нэрлэдэг. *Өвгийн* улстөрийн соёл улстөрийн хөгжил нь хоцрогдонгуй яваа улс орон, бүс нутгуудад хамаардаг. Улстөрийн соёлын эл загвар ёсоор улстөрийн амьдралаа өөрийн овог омог, тосгоноор хязгаарлана. Тэрбээр төв засгийн газарт ямар ч ач холбогдол өгөхгүй, өөрийн ахуйг төрийн бодлоготой огтхон ч хамаатуулж үздэггүй. Улстөрд тэрбээр гагц өөрийн овог омог, тосгоны үнэт зүйлсийн байрнаас ханддаг. Улстөрийн талаар мэдлэг түүнд хомс, улстөрийн мэдээлэл түүний сонирхлыг ер татахгүй, эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөгжөөгүйн улмаас мэдээлэл үл хүрнэ. Улстөрийн амьдрал буцалж байдаг хотод очоод ч мань хүн алс бөглүү нутгийнхаа соёлын хэм хэмжээг баримтлахад гайхах зүйлгүй. Ийм соёлтой хүмүүс хөгжингүй орнуудад ч зарим хэмжээгээр тохиолдох боловч уг соёлын загварын хамгийн түгээмэл зургийг хөгжиж буй орнуудаас харж болдог ажээ. *Албатын* хэв маяг улстөрийн системд



хандсан чиг баримжаа хүчтэй байдаг, тэгсэн атлаа иргэдийн бие даасан идэвх сул байдгаараа бусад загвараас ялгардаг. Ийм соёл бүхий нийгэмд хүн улстөрийн засаглал, засгийн газрын талаар тодорхой төсөөлөлтэй, түүнд эерэг, эсвэл сөрөг хандаж байдаг. Гэвч тэрбээр төр засагтай идэвхтэй хамтран ажиллахад бэлэн биш бөгөөд уламжлал дагаад эсвэл айж эмээснээсээ захирагдаж байдаг. Албатын соёлын загвар улстөрийн харилцаанд зэрэг зиндаа, шатлалыг чухалчилдаг феодалын улстөрийн системд бий болсон гэж үздэг. Энэ нөхцөлд удирдагч доод тушаалын албатуудаасаа ажил хэрэгт бус харин өөртөө үнэнч байхыг хүлээж байдаг байна. Гэвч өнөө үед уул хэв маяг хаан, аль эсвэл дээд удирдагчдаа хүндэтгэлтэй хандахыг иргэний өндөр ухамсар, бие хүний оролцоотой хослуулдаг нийгэмд байсаар ажээ. *Оролцооны* хэмээх улстөрийн соёл хамгийн хөгжиж боловсорсон загвар юм. Уг соёлын нөхцөлд хүн улстөрийн системд хандаж түүний талаар сайн төсөөлөлтэй, түүнд нөлөөлөхийг эрмэлзэж байдаг. Хэрэв биечлэн оролцохгүй бол улстөрийн систем амьдралд нь сөрөг нөлөөлж болзошгүй хэмээн болгоомжилж, тэрбээр эсвэл улстөрийн талаар адилсаж, аль эсвэл түүний үнэт зүйлсийг шүүмжилж няцааж байдаг. Ийм учраас хүн улстөрийн амьдралд идэвхтэй татагдан оролцож улстөрийн үйл явцын үе шат бүрт нөлөө үзүүлэхийг хичээдэг байна. Улстөрийн соёлын эдгээр хэв маяг цэвэр байдлаараа улстөрийн амьдралын олон талт, нарийн төвөгтэй шинжийг тусгаж чадахгүй нь мэдээж. Иймээс бодит байдал дээр улстөрийн соёлын хэв маягууд ихэвчлэн холимог байдлаар оршино. Тухайлбал, *өвөг-албатын, албат-оролцооны, өвөг-оролцооны* улстөрийн соёлуудыг нэрлэж болно. Улстөрийн соёлын янз бүрийн загваруудын харьцаанаас хамааруулан тухайн орныг улстөрийн харилцаа талаас хэр зэрэг хөгжснийг авч үзэж болох юм. Өндөр хөгжилтэй ардчилсан улсад оролцооны улстөрийн соёлын төвшин 60, түүнээс дээш хувьтай байх ба өөрөөр хэлбэл хүн амын 60-аас доошгүй хувь нь улстөрийн амьдралд харьцангуй идэвхтэй оролцож байх ёстой. Хүн амын үлдсэн хэсэг өвгийн болон албатын соёлтой байх юм. Г.Алмонд мөн түүх-соёлын уламжлалыг харгалзан англи-америкийн, эх газрын европын, аж үйлдвэржилтээс өмнөх, тоталитар гэсэн улстөрийн соёлын дөрвөн хэв маягийг ялгаж үзсэн байдаг. *Англи-америкийн* соёл секуляр шинж, прагматизмаараа бусад соёлоос илүүтэй ялгардаг ажээ. Энд улстөр “баян”, “ядуугийн” хоорондын хурц ширүүн тэмцэлгүйгээр нийгмийн янз бүрийн бүлгүүдийн хэрэгцээ шаардлага, боломж бололцооны илэрхийлэл болж байдаг. Улстөрийн соёлын эл хэв маяг нэг төрлийн шинжтэй. Энэ нь зарим суурь үнэт зүйлс, баримтлах тоглоомын дүрмийн хувьд нийт үндэстний зөвшилд хүрсэн байдаг гэсэн үг. Сонгуульд ялагдал хүлээсэн нам яагаад ч өөрийгөө бусдаас илүү байсныг нотлохоор яарч тэвдэх биш харин үүнийгээ боловсон аргаар батлахын тулд дараачийн сонгуулийг хүлээх тэвчээр суусан байх жишээтэй. Америкийн хоёр намын систем ялсан нам зоорилгодоо хүрэхийн тулд радикализм болон экстремизм рүү хальтралгүй, нийт үндэстний зөвшил, тоглоомын дүрмийг сахин мөрдөх замаар үйл ажиллагаандаа төв байр суурийг хэрхэн баримталдагийг харуулж чаддаг гэж үзсэн байна. *Эх газрын-европын* соёлын хэв маягийг Г.Алмондын үзснээр холимог, эсвэл шилжилтийн гэж болох юм. Улстөрийг бүлгүүдийн ашиг сонирхлын тэмцэл гэж үзэхийн хамт “хэн нэгэнд найр тавих боломжгүй” эрхэмлэл, зарчмуудын тэмцэл гэдэг ойлголт амь бөхтэй хадгалагдаж байдаг ажээ. Сонгогчид баруун, зүүнээр талцан хуваагдснаас намууд хэний талд байх, ямар ашиг сонирхлыг илэрхийлэхээ тод томруун үзүүлэхийг хичээдэг байна. Үүний улмаас ялсан нам бүр “үндэсний түүхээ дахин шинээр бичихийг” эрмэлздэгээс үе үеийн давалгаа, тасалдал тохиолдох нь цөөнгүй байдгийг Европын зарим орнуудын улстөрийн түүх харуулдаг байна. *Аж үйлдвэржилтээс өмнөх* холимог улстөрийн соёл нь уламжлалт ба барууны институтууд, үнэт зүйлс, хэм хэмжээ, чиг баримжаа зэрэгцэн оршиж байдгаар онцлог

ажээ. Парламент, сонгуулийн систем, бюрократ зэрэг өрнөдийн улстөрийн үндсэн гол шинжийг илэрхийлдэг институтүүдийг тухайн орнуудын уламжлалт бодит байдалд ямар нэг байдлаар өөрчлөгдсөн хэлбэрээр буулгасан байдаг. Үүний үр дагавар болж онцлог улстөрийн соёл үүсэх бөгөөд түүнийг Алмонд М.Веберын нэр томъёог хэрэглэж *харизмат улстөрийн соёл* хэмээн нэрлэсэн байна. Эл соёл гол төлөв уламжлалт хэм хэмжээ, урьд нь ариун нандинд тооцогддог ёс заншил алдагдан тодорхойгүй байдал үүссэн нөхцөлд бий болно. Хүмүүс тогтвортой байдал, аврал хамгааллыг эрж харизмат лидерт найдлага тавьдаг. Ийм хэв маягийн улстөрийн оёл хөгжиж буй орнуудад давамгайлж байдаг. *Тоталитар* улстөрийн соёл дээр дурдсан улстөрийн соёлын хэв маягуудаас эрс ялгаатай. Ийм улстөрийн соёл өнгөц ажиглахад нэг төрлийндүү боловч энэ нь зохиомол шинжтэй байдаг. Хэрэг дээрээ улстөр-үзэл санааны плюрализм байдаггүй учраас сайн дурын байгууллага, эвсэл холбоод зохион байгуулагдаагүй, олон намын өрсөлдөөн, чөлөөт сонгууль хаалттай, хэвлэл мэдээллийн хэрэгслийг төвөөс хянадаг зэрэг нь иргэдийн улстөрийн системдээ хандах чиг баримжааг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг нь ойлгомжтой. Г. Алмонд эдгээр улстөрийн соёлын хэв маягийг шалгуур болгож улстөрийн системүүдийг хэв маягчилсан байдаг нь улстөрийн соёлын үзэл баримтлалыг улстөрийн шинжилгээнд бодитой ашигласны жишээ гэж болох юм. Үүнээс гадна улстөрийн соёлыг эрдэмтэд нэгдмэл, хуваагдмал, зах зээлийн, этатист гэх зэргээр янз бүрийн шалгуураар ангилсан нь буй. Гэхдээ улстөрийн соёлын хэв маягийг дээр өгүүлсэн үндэслэлүүдээр хязгаарлаж болохгүй нь мэдээж. Жишээ нь, үнэт зүйлс, уламжлал нь хэрэг дээрээ дэлхий дээрхи бүх улстөрийн соёлуудын суурь болж өгдөг Өрнө, Дорнын соёл иргэншлийн өвөрмөц онцлогтой уялдаатай хэв маягчлалын илүү ерөнхий шалгууруудыг ашигласан байдаг. Тухайлбал, *Өрнийн улстөрийн соёлын* үнэт зүйлс нь нийтийн асуудлуудыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоо заавал шинжтэй байдаг Эртний Грекийн засаглалын хот-улсын зохион байгуулалт, бие хүний иргэний бүрэн эрхийг баталсан ромын эрх зүйгээс эх үндсээ авсан байна. Тэдгээрийн агуулгад христос, юуны өмнө протестант, католик шашны үнэт зүйлс асар нөлөөлсөн гэж үздэг. *Дорнын соёлын* хэм хэмжээ, уламжлалын онцлог нь араб-мусульман, күнз, хинди-буддын соёлын үнэт зүйлсийн нөлөөн дор төлөвшсөн азийн хөдөө аж ахуйн нийгмийн элгэн хүйн бүтцүүдийн амьдрал, үйл ажиллагааны өвөрмөц шинж чанарт оршдог ажээ. Энэ хоёр соёл дахь иргэдийн улстөрд хандах үнэт зүйлсийн чиг баримжааг зарим талаас нь харьцуулж үзвэл:

*Өрнөдийнхөн* улстөрийг засгийн эрх мэдлийн шударга өрсөлдөөн, иргэд хуулийн өмнө тэгш байх зарчимд үндэслэсэн нийгмийн зөрчилт үйл ажиллагааны төрөл гэсэн байдлаар ханддаг бол *дорныхон* улстөрийг дуртай хэн нэгний биш, харин бурхан тэнгэрийн таалал, эрэлхэг баатруудын үйл ажил хэмээн үзэхийн хамт улстөрийн үйл явдлуудын тохиолдлын шинжийг үгүйсгэж, улстөрийг зөвшилцөл, зохицол, амар амгаланг тогтоох арга хэмээн ойлгодог ажгуу. *Өрнийн* улстөрийн соёл хувь хүний эрх чөлөөг эн тэргүүнд тавьж хувь хүнийг улстөрийн гол субъект, засаглалын эх сурвалж гээд төр бол иргэний нийгэм, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилтаас хараат байх ёстой институт хэмээн ханддаг бол *дорнын* улстөрийн соёл улстөрд элитүүд, төрийн тэргүүлэх үүргийг тодотгож, иргэдийг төрөөс ивээж халамжлахыг чухалд тооцож, хамт олны удирдагчдыг хувь хүнээс дээгүүр тавихыг хүлээн зөвшөөрдөг. *Өрнөдөд* хувь хүн улстөрийн амьдралын олон олон хэлбэрүүд, улстөрийн өрсөлдөөнт оролцоо, олон ургальч байдал, засаглалын нарийн нийлмэл зохион байгуулалтыг урьдал болгодог бол *дорно дахинд* хувь хүн улстөрийн амьдралд үүрэг гүйцэтгэх, хувийн хариуцлага хүлээх гэхээс илүү улстөрд хамтаараа оролцохыг эрмэлзэж, засаглалын авторитар хэв маяг, засаглалын зохион байгуулалтын энгийн хялбар хэлбэрт болон харизмат удирдагчид татагдах

хандлагатай байдаг аж. *Барууны* соёлд элитүүд, эрх баригчдын нийгмийг удирдах үүргийн биелэлтэд *рациональ* хандаж, тэдний үйл ажиллагааг хянах шаардлагын тухай ойлголт хэвшсэн байдаг бол *дорнын* соёлд эрх баригчид, нийгмийг удирдах тэдний үйл ажиллагааг биширч дагах нь элбэг, иймээс удирдагчаа хянах ойлголт, эрмэлзэл дутмаг байдаг. *Өрнөдийн* иргэд нийтээр мөрдөх төрийн хууль тогтоомжыг хувийн хэм хэмжээ, үйл байдлын хэв загварын дээр тавьж, иргэдийн улстөрийн үйл байдлын зан суртхууны ба хууль зүйн сэдлийг ялгаж салгаж үздэг. *Дорныхон* орон нутгийн дүрэм журам, ёс заншилд төрийн албан ёсны дэг жаягаас илүүтэй ач холбогдол өгч, улстөрийн үйл байдлын сэдэл болдог ёс суртхуун ба хууль ёсны хоорондын зөрчлийг зөөлрүүлж арилгах хандлагатай гэж үздэг байна.

Хэрэг дээрээ төр-иргэний хоорондын харилцааг зохицуулж ирсэн эдгээр үнэт зүйлс, уламжлал нь сонгодог хэлбэрээрээ эсрэг тэсрэг улстөрийн соёлуудыг бүрдүүлдэг. Эдгээр соёлын аль нэг загварын дагуу улстөрийн институтүүдийг өөрчлөн байгууллаа гэхэд заримдаа өмнөх соёлын зарим үнэт зүйлсийг төдийлөн “ганхуулж” дөнгөхгүй байх нь цөөнгүй. Жишээ нь, Энэтхэг улс Их Британы колоничлолын суурин дээр чамбай хөгжсөн намын систем, парламентын бүтэц мэтийг өвлөн авсан ч улстөрийн амьдралд нь аанай л дорнын менталитет давуутай үйлчилсээр ажээ. Сонгуульд намуудын мөрийн хөтөлбөрөөс илүүтэй тосгоны ахлагч нар, шашин омгийн тэргүүнүүдийн санал үнэ цэнэтэй байдаг нь үүний гэрч. Үүний хамт баруун Европын зарим улсуудад дорно зүгийн шашин, аж төрөх ёсыг ихэд шохоорхон сонирхдог боловч тэр нь тэндхийн улстөрийн соёлын хэмжигдхүүнүүдийг өөрчлөхөд яагаад ч гавьтай зүйл болдоггүй ажээ. Үүний зэрэгцээ Япон мэтийн зарим улсуудад өрнийн хийгээд дорнын үнэт зүйлсийн синтез бий болсныг бас үгүйсгэх аргагүй. Монголын нийгэмд ч өрнө-дорнын үнэт зүйлсийн эрчимтэй “диалог” болж байгааг улстөрийн ардчилал, зах зээлд шилжиж буй манай үйл явц бэлхнээ харуулсаар бөлгөө.

Монголын улстөрийн соёл дорнын уламжлал, нүүдлийн соёл иргэншлийн түүхэн онцлогтой уялдан суурьшмал хийгээд газар тариалангийн соёлоос өвөрмөц шинжээрээ ялгардаг. Тал нутгийн нүүдэлчин ард түмний байгал, түүх, аж төрөх ёс, ертөнцийг үзэх үзлээс үүдэн тэдний улстөрийн төсөөлөл, итгэл үнэмшил, үнэт зүйлс төлөвшиж бий болсон. Монголчууд эртнээс хаан эзнээ тэнгэр язгууртай, ард олныг хошуучлахаар хүлээн зөвшөөрөгдсөн хэмээн үздэг *төрөө шүтэн дээдлэхүй* нь тэдний улстөрийн соёлын тулгуур үнэт зүйл болж иржээ. “Төрийн сүлд минь өршөө” хэмээн залбирдаг нь монгол хүний төрдөө хандах чиг баримжааны тод илэрхийлэл юм.

Монгол үндэстэн түүхийн зуун зууны нугачааг туулан өөрийн гэсэн төр ёсыг бий болгохдоо төрийг хүчирхийллийн, эсвэл ашиг арилжааны хэрэгсэл гэж үзэж байгаагүй бөгөөд харин *авран хамгаалагч, шударга үнэний биет цогцлол* хэмээн хүлээн авч, тэр дундаа хүчтэй, төвлөрсөн төрийг илүүтэй эрхэмлэж байсан нь нүүдлийн ахуйгаас улбаатай байгал газар зүйн хийгээд ах зах, ихэс дээдэс, ёс жудагаа хүндэтгэн дагадаг нийгэм-соёлын хүчин зүйлсээр нөхцөлдөж байсныг гэрчилдэг. *Төрдөө үнэнч зүтгэх нь* хэн бүхний ариун үүрэг гэдэг нь монгол хүний дотоод итгэл үнэмшил болж хувирсныг түүхэн эх сурвалжуудаас мэдэж болно. Монголчуудын хувьд улстөр гэдэг нь гагц эрх мэдлийн төлөө нандин бүхнээ уландаа гишгэсэн *улайрсан тэмцэл* төдийхөн байгаагүй бөгөөд харин хүмүүний нийгэм зохион байгуулагдах жам ёсны тухай гүн ухаан, дагаж мөрдөх үнэт зүйлс, бишрэн тэмүүлэх чин хүслэнгийн тухай цогц үзэл байсан гэх үндэстэй. Нэг үгээр энэ бүхнийг товчлон хураангуйлагч тэнгэрийн үзэл нь улстөр, төрийн тухай үзэл сургаалийн үндэс болж байв.

Монголын суурь улстөрийн соёлд нүүдлийн аж төрөх ёсноос гарвалтай айлсан нөхөрлөх, хамтран аж ахуйгаа эрхлэх, харилцан туслах зэрэг “айл хүний амь нэг” гэсэн *хамтын шинж* түлхүү тусч, явцуу ашиг сонирхлоороо хуваагдан өрсөлдөхөөсөө хүний ёс, эрхэмлэл, нэр төр, үнэт зүйлсийг чухалчилж *бусдын төлөө үзлийг амиа хичээхээс, үүрэг хариуцлагыг эрх ямбаас дээгүүр тавьдаг* нь түүнд онцгой нөлөөтэй байв. Түүнчлэн монголын улстөрийн соёлын бүтцэд домог, шашин, бэлэгдэл ёс нэвт шингэсэн байдаг. Монголчуудын улстөрийн соёлыг бүхэлд нь авч үзвэл *ёс зүй-үнэт зүйлсийн* чиг баримжааг төвд тавьж, *ёс суртхуун, хууль эрх нийгмийн харилцааг зохицуулагчийн хувиар адил зиндаанд тавигдаж*, нэг үгээр ёс зүй нь хуулийн хүчинтэй байсан гэж болно. Эв *еийг* хичээх нь монголын улстөрийн соёлын тулгуур үнэт зүйлсийн нэг мөн. Монголчууд маргалдах, сөргөлдөх, эвдрэлцэхийг уруудаж доройтохын цондон хэмээж, төр түмний хэргийг эв зүйгээр, уужуу тайвуу ухаан зарж шийдэхийг эрхэмлэж иржээ. Түүхийн хүнд бэрх цагт чингэж чадаж байсан жишээ олон буй. Монголын төр ёсны нэг онцлог нь нийгэмд дэг журам тогтоохыг нэн тэргүүний үүргээ гэж үздэг нь *эрх чөлөө, дэг журам гэсэн үнэт зүйлс монголчуудын хувьд эн зэрэгцээ тавигддаг* гэж болно.

Улстөрийн соёлын үнэт зүйлс, уламжлал, хэм хэмжээ нь *харьцангуй тогтвортой* байдгийг бид дурдсан. Гэвч *улсөрийн соёл огт өөрчлөгддөггүй зүйл бас биш*. Шинэ шинэ үйл явдлууд, амьдралын шинэ хэв маяг хувь хүний хандлага, төсөөлөл, итгэл үнэмшлийг өөрчилнө. Үүний нэгэн адил монголын улстөрийн соёл түүхийн турш хувьсан өөрчлөгдсөөр ирсэн нь лавтай.

XX зуун Монгол улсын сэргэн мандал, тусгаар тогтнолын түүхийн баларшгүй мөрүүдийг бичсэн юм. Энэ зууны оргил улстөрийн үйл явдал -1921 оны ардын хувьсгалын эхний жилүүдэд ардчилсан төр, хууль ёс монгол улсын нийгэм-улстөрийн амьдралд биеллээ олох эх суурь тавигдсан. Гэсэн хэдий ч түүхэн нөхцөл байдал, гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр модернизацийн үйл явцад засгийн эрх мэдэл аажмаар нэг намд төвлөрч, үзэл сурталжсан, дайчилгаа давамгайлсан улстөрийн оролцоо бүхий *албатын* улстөрийн соёл улстөрийн системийг бүхэлд нь тодорхойлох болов. Гэвч 70-аад оны дундаас эхэлсэн ардчиллын гуравдагч давалгаа дэлхийн бүс нутгуудыг хамарсаар 90-ээд он гэхэд түүний зах сэжүүрт Монгол өртсөн билээ. Тэр үеэс монголчуудын улстөрийн соёл өрнөжих үйл явц, ардчилал, зах зээлийн нөлөө дор эрс өөрчлөгдөн хувирсаар буйг өнөөгийн бодит ахуй гэрчлэх бөлгөө. Улстөрийн соёлд өрнийн үнэт зүйлс, үйл байдлын загварууд хүчтэй нэвтэрч өөрийн орон зайг эзлэх явцад өмнөх үеийн улстөрийн соёлын элементүүд нэг хэсэг нь түргэн зуур, нөгөө нь аажим өөрчлөгдөж, бас зарим нь хадгалагдсаар байгаа нь өнөөдрийн улстөрийн соёлын дүр зургийг тодорхойлж байна. *Монголын одоо үеийн улстөрийн соёл* ардчилсан улстөрийн системийнхээ мөн чанарт бүрэн утгаар дүйцэж тохирох хэмжээнд хувь хүн, хэсэг бүлэг, нийгмийн төвшинд ч хараахан хүрч очоогүй, олон түмний хийгээд элитийн дэд соёлууд ч сайн бүрэлдэн төлөвшөөгүй байна.

90-ээд онд иргэдийн улстөрийн идэвх “адар”-таа тулж, улстөрийн тухай урьдын хэвшмэл ойлголт, төсөөллүүд “эвдэрч”, харин хүмүүс улстөр гэдэг бол “тэртээ холын” хийсвэр зүйл биш, бас зөвхөн эрх мэдэлтнүүд эрхлэх ажил биш, харин хүмүүсийн өдөр тутмын амьдрал, ашиг сонирхолтой салшгүй хэлхээ холбоотойг гүнзгий ухаарч, хүн бүрт шахам улстөрд оролцох, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх эрмэлзэл, мэдрэмжийг сэргээсэн нь *улстөрийн чиг баримжаа, үйл байдалд эргэлтийн шинжтэй өөрчлөлт* гарахад нөлөөлсөн юм. Монголын улстөрийн түүхэнд анх удаа төр, иргэний нийгэм хэрэг дээрээ зааглагдаж, улмаар нам, төрийн дээд удирдлагын хурц шүүмжлэл, огцролт нь монголчуудын хэзээнээс хаандаа “халддаггүй” уламжлалыг “ганхуулж”, төрийг үзэх үзэл хийгээд тухайн улстөрийн дэглэм, төр

хийгээд төржсөн намыг ялган салгаж ойлгоход хүргэсэн билээ. Нийгмийн янз бүрийн хэсэг бүлэг, давхаргуудын үзэл бодол ноёрхогч үзэл сурталтай эн сацуу өрсөлдөх болсон нь улстөрийн либералчлалын нөхцөлд л бололцоотой байв.

Олон түмэн огцом улстөржиж, түүнийг популизм, хэт хувьсгалчирхал дагалдаж, улстөрийн тэмцэл хөдөлгөөн сэтгэл хөдлөл, хөөрөл тийш хэлбийсээр байсан эгзэгтэй мөчид монголчуудын *уламжлалт соёлын үнэт зүйлс*, тухайлбал, эв эеэ хичээх, төр ёсоо бодох, хүлээцтэй уужуу тайвуу ухаанаар хандах нь үйл явцыг тогтоон барьж зөв голдиролоор нь явуулахад тулхтай хүчин зүйл болж байв. Үүний тоймтой баталгаа нь засгийн эрх мэдэл улстөрийн нэг хүчнээс нөгөөд тайван замаар шилжиж чадаж байсанд оршино. Үүний зэрэгцээ үндэстний менталитетаас улбаатай улстөрийн үйл байдлын илрэлүүд ч цөөнгүй ажиглагджээ. Жагсаал цуглаан, өлсгөлөн, ажил хаялт, огцруулалт, нам эвсэл холбоо, сүм хийд, мэрэг төлөгчид, уул овооны тахилга мэтийн зүсэн бүрийн зан үйл, үйл байдал, үзэл бодол шил шилээ даран гарч ирсэн нь нэг талаас улстөрийн идэвх, олон ургальч үзэл, ашиг сонирхлын ялгаралтай холбоотой байсан хэдий ч нөгөө талаас тал нутгийнхны аливаад туйлшрамтгай сэтгэлгээний стереотипыг ямар нэг хэмжээгээр харуулж өгсөн гэж болох билээ. Хүний эрх, эрх чөлөө л гэсэн бол захирах, захирагдах ёс, ерөөс аливаа засаглал, удирдлага, зохион байгуулалтыг үгүйсгэх, хүнд сурталт тогтолцооны төржсөн намаас татгалзсан бол ерөөс аливаа намаас “зугатах”, ноёлогч үзэл суртлыг халсан бол ерөөс аливаа “изм”-үүд огт хэрэггүй гэх мэт нь туйлшрал, бас төөрөгдөл байв.

Нийгэмд дэлгэрсэн ёс суртхуунгүй явдал, харш үзэгдлүүдэд иргэд амьжиргаанаасаа дутахааргүй санаа зовж байдаг нь монгол хүн нийгмийн аливаа харилцааг эргэцүүлэн тунгаахдаа улстөрийн соёлынхоо суурь “инстинкт”-ээрээ буюу *үнэт зүйл-ёс зүйн* шалгуураар хэмждэгтэй холбон үзэж болох юм.

Түүнчлэн өрнийн нийгэм ихэнхдээ иргэний нийгэм, зах зээлд тулгуурлаж байдаг бол дорно дахинд төрийн үйлдвэрлэлийн арга давуутай байдаг зүй тогтлыг шинэчлэгдэн баяжиж буй улстөрийн соёлын хүрээнд харгалзах хэрэгтэй болно. Монголчуудын улстөрийн соёл *сэтгэл-хөдлөл-мэдрэмжийн* онцлог шинжээрээ ялгарч, иргэд төрөө хүндэтгэх төдийгүй түүнээс эмээх мэдрэмж өндөртэй байсныг дан ганц номхон доройгоор тайлбарлах нь учир дутагдалтай. Иргэн төрөөсөө “гэрэвших” нь цаад утгараа тааж мэдэхийн аргагүй гэнэтийн халдлага, аюулаас айж балмагдахаас ангижирч чаддагаараа “улстөрийн хүн” болдог тухай санааг Гоббс хэлсэн байдаг. Гэтэл нийгэмд ийм мэдрэмж үгүй болсон нь зарим хэсэг өөрсдийгөө ёс суртхуун, соёлын уламжлалаас чөлөөтэй, айх ичих зүйлгүй мэт бодож, төрийн институтүүд, хэм хэмжээ өөрт нь огт падгүй мэт санахад хүргэсэн байна. Үүнээс үүдэн төр-эрх зүй, ёс зүйн зохицуулалт суларч, хууль ёсыг үл тоох, дураар дургих, дэг журамгүй, сахилга зохион байгуулалтгүй байдал хавтгайрчээ. Энэ бүхэн монголчуудын улстөрийн соёлын төр ёс, ёс жудагаа гэсэн үнэт зүйлсийн нийгмийн үүрэг үгүйлэгдсээр буйг гэрчилнэ. Ер нь улстөрийн шинэ соёл соёолох үр үндэс нь монгол ахуйгаас ургаж төлжсөн иргэн төртэйгөө, иргэд хоорондоо харилцах хэм хэмжээ, түүхийн сорилтыг даван туулсан төр ёсны дэвшилт олотууд, үнэдсний ардчилсан, иргэнлэг өв сан байх ёстой гэдэгтэй санал нийлэхээс аргагүй ажээ.

Ийнхүү Г.Алмонд, бусад эрдэмтдийн улстөрийн соёлын ялгарах шинжүүдийг тодорхойлоход санал болгосон харизм, фрагментар шинж, хамтач ёс, уламжлал, хувь шинж, нэг төрлийн байдал, зөрчил, зөвшилцөл гэх мэтийн шалгуурууд ямар нэг хэмжээгээр улстөрийн соёлуудад тусгалаа олсон нь ажиглагдаж байна. Гэвч тэдгээрийн хослол, хүч нөлөө, ач холбогдол улстөрийн соёлын хэв маяг бүрт, үндэсний соёл болгонд өөр өөр байгаа нь илт. Энэ утгаар орчин үед ялангуяа хүйтэн дайны шувтарга өнөө үед улстөрийн соёлын *холомог* хэв маягуудтай дэлхийн

улстөрд олонтаа тааралдаж байгаа нь зүй ёсны асуудал мөн. Тухайлбал, ардчилалд шилжиж буй улстөрийн системүүдэд нэг талаас авторитар, эсвэл уламжлалт элементүүд, нөгөө талаас ардчилсан үнэт зүйлс зэрэгцэн оршсоор байгаа нь баримт юм. Иймээс дээр дурдсан улстөрийн соёлын хэв маягууд бүхэлдээ идеалчилсан шинжтэйг анхаарах учиртай.

Улстөрийн соёл цаг хугацаа, орон зайнаас хамааран өвөрмөц онцлогтой байдаг. Иргэдийн улстөрийн суурь үнэлэмж, итгэл нэмшил нь хувийн туршлага, улстөрийн нийгэмшлийн агентуудын нөлөө дор төлөвшдөгийг бид дурдсан. Дэлхийн олон үндэстнүүдийн улстөрийн соёл өөр хоорондоо хичнээн их ялгаатай, олон янз байдаг нь илэрхий билээ. Гэвч гадаад орчин, дэлхий дахины шинжтэй түүхэн үйл явдлуудын нөлөөгөөр улс түмнүүдийн улстөрийн соёл өөрчлөлтийн үр шимийг ямар нэг хэмжээгээр “амсаж”, ерөнхий чиг хандлагатай болж байдгийг зориуд тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, дэлхийн улсуудын хөгжил, аж төрөх ёс, улмаар улстөрийн соёлд нь гүнзгий ул мөрөө үлдээсэн, өнөөдөр ч хүчтэй нөлөөлсөөр буй үйл явдал, үзэгдлүүд, хүчин зүлсийн тоонд модернизаци, секуляризм, үндэсний ухамсар, шашны фундаментал үзэл, постматериаллаг үнэт зүйлс, ардчиллах үйл явц, чөлөөт зах зээл зэргийг нэрлэж болно. Жишээ нь, дэлхийн хэмжээнд нийтлэг үнэт зүйлсийг өөрчилж буй соёлын хөгжлийн гол чиг хандлага бол *модернчилал* юм. Өнгөрсөн 200 орчим жилд байгалийг захирах хийгээд шашнаас ангижруулагч шинжлэх ухааны нөлөө эдийн засаг, нийгмийн системүүдийг үндсээр нь өөрчилж, эхлээд өрнөдөд, дараа нь аажмаар бүх дэлхийд улстөрийн соёлыг өвөрмөц онцлог хэлбэр, шинжтэй болгосон юм. Ажил хөдөлмөр, боловсрол, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжин шинэ зүйлсийн нөлөө хувь хүний мэдлэг, туршлагыг баяжуулж улмаар эдгээр хүмүүс бусад нийгмийг шинэ бүхэнтэй танилцуулдаг. Үүний хамт аж төрөх ёсны дасал болсон хэвшлүүд, легитимийн уламжлалт үндсүүд, албатууд, өвгийнхний дунд давамгайлсан улстөрийн дэг журмуудад ан цав суулгаж ганхуулдаг.

Нийгэм-эдийн засаг, улстөрийн модернизацийн үр дүнд хөгжингүй орнуудад аж үйлдвэржилтийн дараахь нийгэм бий болсон байна. Олон улсын энх тайван, эдийн засгийн асар хурдан хөгжлийн нөхцөлд өсч бойжсон хойч үе эцэг эхтэйгээ харьцуулахад одоогийн материаллаг аж байдал, хувийн аюулгүй байдлынхаа талаар сэтгэл зовох нь багасчээ. Үүний оронд залуучууд нийгмийн тэгш байдал, хүрээлэн буй орчныг хамгаалах, соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх, өөрийгөө илэрхийлэх зэрэг *постматериаллаг үнэт зүйлсийг* илүүтэй үзэх болсон байна. Эдгээр үнэт зүйлс нь байгал хамгаалах болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах бусад олон эвсэл холбоод зэрэг иргэдийн шинэ шинэ бүлгүүд үүсэх эх ундарга болж өгчээ. Өөрчлөгдөж буй үнэт зүйлс аж үйлдвэржсэн ардчилсан орнуудын улстөрийн бодлогыг өөр өнцгөөс харахад хүргэж, улам олон иргэн хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, нийгмийн ба улстөрийн эрх чөлөөг өргөтгөх, нийгмийн тэгш байдлыг хангах бодлогыг онцлон үзэхийг засгийн газруудаасаа уриалах болжээ.

Дэлхийн олон бүс нутагт иргэдийн мэргэжил боловсрол дээшилж, өөртөө итгэх итгэл өсөхийн хэрээр урьд өмнө хавчигдаж гадуурхагдаж байсан угсаатны бүлгүүд өөрсдийн адилслыг илэрхийлж, өөрсөддөө тэгш хандахыг шаардаж эхэлсэн байна. Тэдгээр үндэстэн угсаатны бүлгүүд бэлгэ тэмдэг, түүх соёлын уламжлалаа эрхэмлэх болсон нь *үндэсний ухамсар сэргээхэд* их нөлөөлж байгаа ажээ.

Сүүлийн 20-30 жилийн дэлхийн хамгийн чухал үйл явдал манай гаригийн олон бүс нутагт улс орнууд *ардчиллын замаар* замнах болсонд оршино. Модернизаци ардчилсан биш дэглэмүүдийн үзэл суртлын легитимийг алгуур элээж улмаар иргэдийн улстөрийн оролцоог идэвхтэй, өргөн цар хүрээтэй болгож өгсөн байна. Иргэд ардчилсан хэм хэмжээ, үнэт зүйлс, үзэл санааг дэмжих нь олон улсын хамтын

нийгэмлэгт ардчилалд шилжиж буй улс орнуудын эзлэх хувь нэмэгдсээр байгаагаас зарим талаар харж болох юм. Сүүлийн үеийн улстөрийн соёлын өөр нэг чиг хандлага бол зах зээлийн зарчмыг дэмжин хүлээн авч байгаа явдал юм. Төрийн оролцоог хумих, үүний оронд эдийн засагт чөлөөт зах зээл, хувийн бизнес санаачилгыг дэмжих үзэгдлээр илэрч байна. Эдгээр чиг хандлагууд улстөрийн соёлд хувьсгалжуулагч нөлөө үзүүлж байна гэж дүгнэж болох юм.

Улстөрийн соёл хөдөлгөөнгүй царцанги үзэгдэл биш нь илэрхий. Улстөрийн соёлын тухай бидний ойлголт урагшилж хөгжих ёстой. Энэ үйл явц улстөрийн нийгэмшлийн субъектууд түүхэн үйл явдлууд, уламжлалт үнэт зүйлсийг хэрхэн дамжуулж, тайлбарлаж байдгийг өөртөө багтаадаг. Нэг үе нөгөөгөөр аажмаар солигдох нь улстөрийн соёлыг байнга шинэчилж өөрчилж байна гэсэн үг. Улстөрийн хөгжил ямагт шинэ туршлага, шинэ үзэл санааг дагаж, бас дагуулж байдаг гэж болно.

### Ном зүй

- Almond, G. Verba, S. (1963) The Civic Culture (Princeton, N.J.: Princeton University Press).
- Almond, G. Verba, S. (eds) (1980) The Civic Culture Revisited (Princeton, N.J.: Princeton University Press).
- Huntington S. (1996) A New Era in Democracy: Democracy's Third Wave // Comparative Politics. 96/ 97, 14th ed. USA.
- Inglehart,R. (1990) Culture Shift in Advanced Industrial Countries. Princeton University Press. N-J.,
- Putnam (1993) Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy. Princeton University Press. N-J.,
- Pye,L. Verbe S.(1965) eds. Political Culture and Political Development. Princeton.
- Pye,L. (1995) Asian Power and Politics. The Cultural Dimensions of Authority. USA.
- Slann,M. (1998) Introduction to Politics. Governments and Nations in the Post Cold War Era. USA.
- Бурлацкий Ф.М. Галкин А.А. Социология. Политика. Международные отношения. М., 1974
- Гаджиев К.С. Введение в политическую науку. Логос. М., 1997
- Гердер И. Идеи к философии истории человечества. М., 1977